



ТАНИЛЦУУЛГА

Үндэсний Статистикийн хорооноос Монгол улсын эдийн засаг, нийгэмд COVID-19 цар тахлын нөлөөллийн талаарх 2020 оны эхний 8 сарын төлөв байдлын ээлжит танилцуулгыг бэлтгэлээ.

ҮСХ-ноос 2020 оны 9-р сарын 14-ний өдөр тархаасан нийгэм, эдийн засгийн байдлын статистик мэдээллээр 2020 оны эхний 8 сарын байдлаар улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс


- ↓ Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 18.4,
- ↓ Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 25.5%,
- ↓ Экспорт 16.9%,
- ↓ Импорт 15.6%
- ↓ Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 20.9% тус тус буурч,
- ↑ Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2.1%,
- ↑ Улсын нэгдсэн төсвийн зарлага, цэвэр зээлийн хэмжээ 32.1%,
- ↑ Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 15.6%-аар тус тус өссөн байна.



ИНФЛЯЦ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 8 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 1.0 хувиар буурч, өмнөх оны эцсээс 2.3 хувь, өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар хувиар өссөн байна.

Зураг 1. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь өмнөх оны мөн үетэй харьцуулснаар




Инфляцын түвшин 2017 оны 8 дугаар сард 5.0 хувь, 2018 оны 8 дугаар сард 6.0 хувь, 2019 оны 8 дугаар сард 8.9 хувь гарч байсан бол 2020 оны 8 дугаар сард 2.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 6.8 пунктээр буурсан байна.

Инфляц төв банкны зорилтод түвшнээс (8%) буурч байгаа нь эдийн засгийн идэвх суларсныг илтгэж байна.

Инфляцын түвшин 2020 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 2.1 хувь гарсны 1.2 нэгж буюу 57.1 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгээс, 0.7 нэгж буюу 33.3 хувь нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Зураг 2. Мах, махан бүтээгдэхүүний оролцооны түвшин, 2019, 2020 оны 8 дугаар сард



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2020 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 4.0 хувиар өссөн хэдий ч инфляцад үзүүлж буй оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 9.1 пунктээр буурсан байна.

Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг 13 хүнсний зах, худалдааны төвд хийсэн 32 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн 2020 оны 09 дүгээр сарын III долоо хоногийн ажиглалтаар өмнөх долоо хоногтой харьцуулахад 11 нэрийн барааны үнэ (34.4%) тогтвортой, 5 нэрийн барааны үнэ (15.6%) буурсан, 16 нэрийн барааны үнэ (50.0%) өссөн байна.

≈ Үнэ тогтвортой	↓ Үнэ буурсан	↑ Үнэ өссөн
<ul style="list-style-type: none"> “Алтан Тариа” савласан гурил дээдийн дээд “Алтан Тариа” савласан гурил II “Сүү ХК” тараг, Цөцгийтэй Шар будаа Цөцгийн тос, “Сүү” ХК Элсэн чихэр, “Заантай” Ногоон цай, “Сtimo” Адууны мах, ястай Төмс, монгол Хүрэн манжин, монгол Өндөг, ОХУ 	<ul style="list-style-type: none"> Ургамлын тос, “Янта” Хонины мах, ястай Ямааны мах, ястай Лууван, монгол Байцаа, монгол 	<ul style="list-style-type: none"> “Алтан Тариа” задгай гурил дээд “Алтан Тариа” задгай гурил I “Алтан Тариа” савласан гурил дээд “Алтан Тариа” савласан гурил I “Сүү” ХК савласан 1 л сүү “Сүү ХК” савласан 0.5 л сүү Сүү, Задгай Талх, “Атар” Талх, “Зууван чех” Талх, “хөх тарианы хар” Цагаан будаа, “Заантай” Хонины мах, цул Үхрийн мах, цул Үхрийн мах, ястай Сонгино, хятад Алин, фүжи

Хонины ястай махны үнэ 2020 оны 9 дүгээр сарын III долоо хоногт нэг килограмм нь дунджаар 9185 төгрөг болж, өмнөх сарын дундажтай харьцуулахад 685 төгрөгөөр (6.9%) буурсан байна. Энэ долоо хоногийн ажиглалтаар хонины ястай мах “Хүчит шонхор” хүнсний захуудад хамгийн

хямд буюу 7500 төгрөгөөр, харин "Саруул" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 12000 төгрөгөөр худалдаалж байна.

Хүснэгт 1. Нэг килограмм хонины ястай махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

Хонины ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2014	6 855	6 675	7 040	7 630	7 800	7 685	7 030	6 585	6 395	5 965	5 835	5 940
2015	5 860	6 140	6 735	7 460	7 555	7 455	6 830	6 050	5 540	4 510	4 200	3 930
2016	4 625	5 495	5 970	6 935	6 945	6 525	5 780	5 605	4 940	4 250	3 945	4 390
2017	5 650	6 030	6 675	7 080	7 235	6 700	6 575	6 395	6 210	5 760	5 380	5 140
2018	5 240	5 945	6 560	7 290	7 490	7 515	7 535	6 980	6 415	6 440	6 690	6 695
2019	7 170	7 340	7 945	8 710	9 820	10 430	10 045	9 700	9 640	9 095	7 710	7 635
2020	8 705	9 600	9 765	9 835	10 125	10 385	10 650	9 870	9 185*			

Үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 11265 төгрөгийн үнэтэй байгаа ба өмнөх сарын дундажтай харьцуулахад 495 төгрөгөөр (4.2%) буурсан байна. Энэ долоо хоногийн ажиглалтаар үхрийн ястай мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 8600 төгрөг, Харин "Саруул" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 14300 төгрөг байна.

Хүснэгт 2. Нэг килограмм үхрийн ястай махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

Үхрийн ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2014	7 980	7 775	8 425	8 370	8 685	8 730	7 955	7 590	7 635	7 550	7 495	7 465
2015	7 415	7 565	7 810	8 080	8 145	8 445	7 985	7 230	7 005	5 975	5 620	5 520
2016	6 165	6 875	7 105	8 170	8 495	7 930	6 950	6 865	6 120	5 235	5 495	5 580
2017	6 775	7 405	7 785	7 985	8 230	7 905	7 725	7 375	7 250	6 945	6 710	6 505
2018	6 615	7 110	7 740	8 365	8 465	8 735	9 085	8 225	7 780	7 845	8 005	8 305
2019	8 875	8 925	9 390	9 635	10 960	11 700	12 280	11 540	11 375	10 950	10 090	9 755
2020	10 535	11 415	11 663	11 735	11 940	12 640	12 760	11 760	11 265*			

Үнийн судалгааны сагс дахь нийт 373 нэр төрлийн бараа, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байдаг. Энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлдэг. Инфляц 2020 оны 8 дугаар сард 2.1 хувь гарсны 23.8 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Импортын барааны үнийн өсөлтийн нөлөөлөл нь өмнөх оны мөн үеэс 7.7 пунктээр буурсан байна.

Хүснэгт 3. Инфляцад импортын барааны үнийн өсөлтийн оролцоо, нэгжээр, жил бүрийн 6 дугаар сард


Үзүүлэлт	2018 VIII		2019 VIII		2020 VIII	
	Пункт	Хувь	Пункт	Пункт	Хувь	Хувь
Ерөнхий индекс	6.0	100.0	8.9	100.0	2.1	100.0
Импортын барааны нөлөө	2.2	36.7	2.8	31.5	0.5	23.8

МӨНГӨ, ЗЭЭЛ

Гадаад валютын албан нөөц энэ оны 7 дугаар сарын байдлаар 3.6 тэрбум америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 0.05 хувь, өмнөх сараас 1.8 хувиар өссөн нь экспорт хумигдаж, гадаад валютын урсгал саарсан энэ үед төгрөгийн ханш огцом сулрахаас сэргийлж байна. Гэхдээ валютын нөөц хязгаартай тул экспортыг нэмэгдүүлэх, валютын орох урсгалыг сайжруулах ажил зайлшгүй шаардлагатай байна.

Төгрөгийн тогтвортой байдлыг хангахад нөгөө талдаа иргэдийн төгрөгт итгэх итгэл шууд нөлөөтэй. Өнгөрсөн оны 8 дугаар сарын эцэст нийт хадгаламжийн 21.3 хувийг валютын хадгаламж эзэлж байсан бол энэ оны 8 дугаар сарын эцэст 29.4 хувь болж, 8.1 пунктээр өссөн байна. Валютын хадгаламж 4.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 74.0 (1.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1.7 (58.6%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Зураг 3. Төгрөг болон валютын хадгаламж, сарын эцэст, тэрбум төгрөг



Нийт хадгаламжид валютын хадгаламжийн эзлэх хувь нэмэгдэж байгаа нь иргэд, ААНБ-ын төгрөгт итгэх итгэл суларч эхэлснийг харуулж байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш 2020 оны 8 дугаар сард 2849.11 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар, өмнөх сараас 0.4 хувиар суларсан байна.

Төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2020 оны 8 дугаар сард 411.18 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8.7 хувиар, өмнөх сараас 1.7 хувиар суларсан байна.

Төгрөгийн рубльтэй харьцах сарын дундаж ханш 2020 оны 8 дугаар сард 38.60 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар, өмнөх сараас 2.6 хувиар чангарсан байна.

Хүснэгт 4. Монголбанкнаас зарласан төгрөгийн гадаад валюттай харьцах сарын дундаж ханш, төгрөгөөр, жил бүрийн 6 дугаар сард

Үзүүлэлт	2017 VIII	2018 VIII	2019 VIII	2020 VIII	2020.09.18
Америк доллар	2 443.53	2 464.12	2 670.54	2 849.11	2 854.58
Жилийн өөрчлөлт, хувиар	11.6	0.8	8.4	6.7	
Сарын өөрчлөлт, хувиар	1.4	0.1	0.3	0.4	
Юань	366.29	359.65	378.16	411.18	421.78
Жилийн өөрчлөлт, хувиар	11.3	-1.8	5.1	8.7	
Сарын өөрчлөлт, хувиар	2.9	-1.9	-2.3	1.7	
Рубль	41.03	37.18	40.66	38.60	37.96
Жилийн өөрчлөлт, хувиар	21.8	-9.4	9.4	-5.1	
Сарын өөрчлөлт, хувиар	1.3	-5.0	-3.3	-2.6	

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 8 дугаар сарын эцэст 17.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 53.2 (0.3%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 876.9 (4.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.8 (50.7%) их наяд төгрөг нь иргэдийнх байна.

Хүснэгт 5. Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, зээлийн ангиллаар, жил бүрийн 8 дугаар сарын эцэст

	2017 VIII	2018 VIII	2019 VIII	2020* VIII	<u>2020* VIII</u> <u>2019 VIII</u>
	тэрбум төгрөг				хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	13 265.0	15 942.9	18 256.3	17 379.4	95.2
Хэвийн зээл	11 154.7	13 556.9	15 360.7	14 276.8	92.9
Хугацаа хэтэрсэн зээл	939.1	1 018.5	982.4	1 136.1	115.6
Чанаргүй зээл	1 171.2	1 367.5	1 913.2	1 966.5	102.8

Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 8 дугаар сарын эцэст 14.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 30.0 (0.2%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 1.1 (7.1%) их наяд төгрөгөөр буурчээ. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 82.1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 2.0 пунктээр буурсан байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 8 дугаар сарын эцэст 1.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 0.3 (0.03%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 153.7 (15.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр өссөн байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 8 дугаар сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 22.9 (1.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 53.3 (2.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.3 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.8 пунктээр өссөн байна.


УЛСЫН ТӨСӨВ

Улсын төсвийн 2020 оны орлогыг хэт өөдрөг төсөөлж, төсвийг 2.1 их наяд төгрөгийн алдагтай баталсан нь цар тахлаас шалтгаалан эдийн засаг тодорхой бус байдалд байгаа энэ үед улсын төсвийг хүнд байдалд оруулж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны нийт орлогыг 2019 оны батлагдсан дүнгээс 1.8 их наяд төгрөг буюу 16.6 хувиар нэмэгдүүлэн 12.9 их наяд төгрөгт хүргэхээр төсөөлсөн боловч энэ оны эхний 8 сарын байдлаар улсын төсөвт 6.1 их наяд төгрөг төвлөрөөд байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1.6 (20.9%) их наяд төгрөгөөр бага байна. Төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2020 оны эхний 8 сард 5.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.2 (17.1%) их наяд төгрөгөөр буурсан байна.

Харин төсвийн 2020 оны нийт зарлагыг 2019 оны батлагдсан дүнгээс 2.3 их наяд төгрөгөөр өсгөн 13.9 их наяд төгрөг байхаар баталсан. Энэ оны эхний 8 сарын байдлаар нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 8.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.0 (32.1%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Зураг 4. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, тэрбум төгрөг



Улсын төсвийн нийт алдагдлыг 2.1 их наяд төгрөг буюу ДНБ-ий 5.1 хувьтай тэнцүү байхаар тооцоолсон бол энэ оны эхний хагас жилийн байдлаар нэгдсэн төсвийн нийт алдагдал 2.2 их наяд төгрөг болж, ДНБ-ий 13.1 хувьтай тэнцэж байна. Харин энэ оны эхний 8 сарын байдлаар төсвийн тэнцлийн алдагдал 2.6 их наяд төгрөгт хүрсэн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлого буурсан нь орлогын 84.8 хувийг бүрдүүлдэг татварын орлого буурсантай холбоотой.

Татварын нийт орлого 2020 оны эхний 8 сард 5.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.1 (17.4%) их наяд төгрөгөөр буурахад орлогын албан татвар 375.5 (22.7%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 245.2 (19.5%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 173.0 (28.9%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 165.8 (10.9%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 80.6 (13.8%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 38.9 (7.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

ОАТ-ын орлого буурахад аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 326.0 (29.0%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Бусад татвар, төлбөр хураамжийн орлого буурахад АМНАТ-ийн орлого 131.6 (39.4%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

НӨАТ-ын орлого буурахад дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ 20.1 (3.2%) тэрбум төгрөгөөр, импортын барааны НӨАТ 90.8 (8.5%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Онцгой албан татварын орлого буурахад суудлын автомашины онцгой АТ 55.1 (31.9%) тэрбум төгрөг, дотоодын архи, дарсны онцгой АТ 13.9 (11.3%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлагын өсөлтөд урсгал зардал 6.6 их наяд төгрөг болж, 1.5 (30.1%) их наяд төгрөгөөр, хөрөнгийн зардал 1.8 их наяд төгрөг болж, 629.6 (55.9%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгийн зардал өсөхөд барилга, байгууламжийн зардал 274.0 (33.2%) тэрбум төгрөг, тоног төхөөрөмжийн зардал 183.3 (4.5 дахин), бусад хөрөнгийн зардал 165.2 (93.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Улсын төсөвт төвлөрч буй ААНОАТ, НӨАТ-ын орлого энэ оны эхний хагас жилд өмнөх оноос буурч байгаа нь дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд доголдол учирсныг харуулж байна.

ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний 8 сард 9.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.2 (18.4%) их наяд төгрөгөөр буурсан байна. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2.2 (25.5%) их наяд төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний 8 сард урьдчилсан гүйцэтгэлээр 6.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.2 (25.5%) их наяд төгрөгөөр буурахад нүүрс олборлолт 2.1 (57.8%) их наяд төгрөгөөр, газрын тос олборлолт 473.6 (69.9%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Зураг 5. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл, салбараар, сараар, тэрбум төгрөг



Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2020 оны эхний 8 сард 2.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.6 (0.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд барилгын материал, метал боловсруулах, тавилга, резинэн болон хуванцар бүтээгдэхүүн, химийн бүтээгдэхүүн, хувцас, нэхмэлийн үйлдвэрлэл 1.7-38.9 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин хүнсний бүтээгдэхүүн, ундаа, цаас, цаасан бүтээгдэхүүн, эм, арьс, арьсан бүтээгдэхүүн, тамхи үйлдвэрлэл 3.2-99.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 6. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар

Салбар	2019		2020*		2020* I-VIII 2019 I-VIII
	VIII	I-VIII	VIII	I-VIII	
	тэрбум төгрөг				хувь
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	73.9	541.8	77.2	559.3	103.2
Мах боловсруулах, консервлох	21.8	131.5	20.7	120.2	91.4
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	2.1	12.4	3.8	17.9	144.8
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	16.4	135.8	15.5	131.7	97.0
Үр тарианы гурлын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүн үйлдвэрлэл	14.6	125.2	17.2	143.6	114.7
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	19.1	136.2	20.1	145.8	107.0
Ундаа үйлдвэрлэл	56.4	464.2	61.5	481.9	103.8

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөхөд мах боловсруулалт, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 3.0-8.6 хувиар буурсан хэдий ч хүнсний бусад бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, жимс, хүнсний ногоо боловсруулалт 7.0-44.8 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хувьд 2020 оны эхний 8 сард спирт, шар айраг, талх, хиам, нарийн боов, нэгдүгээр гурил, тараг, шингэн сүү, бялуу, амтат ус, ундаа, хонины мах, үхрийн мах, хоёрдугаар гурил, савласан ногоон цай, ямааны махны үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 1.4 хувиас 2.8 дахин өссөн байна. Харин дээд гурил, жүүс, зайрмаг, архи, жигнэмэг, бууз, банш, хуушуур, цэвэр ус, гоймон, адууны махны үйлдвэрлэл 1.4-82.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 7. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2019		2020*		2020* I-VIII 2019 I-VIII
		VIII	I-VIII	VIII	I-VIII	
						хувь
Үхрийн мах	т	437.1	793.8	135.6	1 252.6	157.8
Хонины мах	т	707.0	2 572.7	403.7	3 424.8	133.1
Адууны мах	т	1 226.0	8 785.3	82.5	1 515.1	17.2
Ямааны мах	т	192.5	571.4	328.4	1 595.2	2.8 ¹
Хиамаан төрлийн бүтээгдэхүүн	т	575.6	3 610.7	611.6	3 852.1	106.7
Шингэн сүү	мян.л	3 355.6	25 962.3	3 470.4	29 549.3	113.8
Тараг	мян.л	901.4	9 102.4	1 146.3	10 350.3	113.7
Зайрмаг	мян.ш	13 238.3	77 132.8	10 955.5	73 537.5	95.3
Дээд гурил	т	4 173.8	30 955.8	2 891.3	30 517.9	98.6
Нэгдүгээр гурил	т	8 811.6	85 201.2	11 395.9	94 084.9	110.4
Хоёрдугаар гурил	т	1 918.4	9 508.6	1 593.6	16 735.1	176.0
Талх	т	2 428.1	17 978.8	2 779.2	18 917.8	105.2
Нарийн боов	т	1 814.5	13 717.9	2 350.8	14 897.3	108.6
Бялуу	т	182.6	1 437.9	205.2	1 642.6	114.2
Жигнэмэг	т	77.0	724.1	64.6	614.4	84.9
Гоймон	т	722.1	5 769.7	338.6	3 695.3	64.0
Бууз, банш, хуушуур	т	410.3	3 355.6	672.5	2 783.8	83.0
Савласан ногоон цай	кг	7 292.6	60 587.6	14 061.1	113 109.9	186.7
Спирт	мян.л	821.8	7 071.8	1 028.4	7 172.4	101.4
Архи	мян.л	2 138.1	18 330.9	2 441.4	17 225.4	94.0
Шар айраг	мян.л	8 246.9	61 157.9	9 886.8	62 876.5	102.8
Цэвэр ус	мян.л	7 712.9	70 916.8	6 145.7	50 069.0	70.6
Амтат ус, ундаа	мян.л	16 313.9	113 639.2	12 109.6	150 826.1	132.7
Жүүс	мян.л	3 335.8	42 884.8	4 350.0	42 187.6	98.4

¹ Дахин их

ДОТООД ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ


2020 оны эхний хагас жилд үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн 76.4 мянга буюу 79.4 хувь нь худалдаа болон үйлчилгээний салбарынх байна.

Худалдааны салбарын нийт борлуулалт 2020 оны эхний 7 сард 13.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.4 (9.8%) их наяд төгрөгөөр, өмнөх сараас 212.5 (9.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлогын 47.2 хувь нь жижиглэн худалдааны салбарт ногдож байгаа ба жижиглэн худалдааны борлуулалтын орлого энэ оны эхний 7 сард 6.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 972.0 (13.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна.


Улаанбаатар хотод нийт худалдааны салбарын 84.4 хувь ногдож байгаа бөгөөд Улаанбаатар хотын худалдааны салбарын борлуулалт 11.8 хувиар буураад байна.

Зураг 6. Худалдааны салбарын борлуулалт, тэрбум төгрөг



Зочид буудлын салбарын орлого 2020 оны эхний хагас жилд 70.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 45.5 (39.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Харин 2020 оны 2 дугаар улиралд 35.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 19.0 (35.0%) тэрбум төгрөгөөр, өмнөх улирлаас 58.9 (0.2%) сая төгрөгөөр буурсан байна. Үүнд 3, түүнээс дээш одтой буудлын орлого өмнөх оны мөн үеэс 17.7 (44.9%) тэрбум төгрөгөөр, өмнөх улирлаас 4.5 (17.0%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 7. Зочид буудлын салбарын орлого, буудлын зэрэглэлээр, улирлаар, тэрбум төгрөг



Зочид буудлын салбарын орлогод 3 ба түүнээс дээш одтой буудлын орлого 70 гаруй хувийг эзэлдэг ба үйлчлүүлэгчид нь ихэвчлэн гадны иргэд байдаг. Энэ оны хувьд цар тахлын дэгдэлтээс сэргийлж хил хаалттай байгаагаас 3 ба түүнээс дээш одтой буудлууд үйлчлүүлэгчгүй байна гэж хэлж болохоор байна.

Нийтийн хоолны салбарын орлого 2020 оны эхний улиралд 102.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.8 (2.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх улирлаас 25.9 (20.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Харин 2020 оны 2 дугаар улиралд 111.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 9.3 (7.7%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх улирлаас 8.4 (8.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Коронавируст халдварын дэгдэлтээс урьдчилан сэргийлж, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/223 тоот захирамжийн дагуу бүх төрлийн баар, бүжгийн клубийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож, ресторан болон бусад нийтийн хоолны газруудын ажиллах цагийн хуваарийг 22:00 цаг хүртэл болгон багасгаснаар рестораны орлого өмнөх улирлаас 18.2 хувь, баарны үйл ажиллагааны орлого 64.9 хувь, кафены орлого 27.7 хувь, гуанзны орлого 26.6 хувь, захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээ 8.8 хувиар буурахад хүргэсэн байна.

Харин Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/590 тоот захирамжийн дагуу согтууруулах ундаагаар үйлчилдэг ресторан, пабын ажиллах цагийн хуваарийг 00:00 цаг хүртэл сунгаснаар баарны орлого өмнөх улирлаас 230.5 (13.6%) сая төгрөгөөр буурсан хэдий ч рестораны орлого 6.3 (10.2%) тэрбум төгрөг, захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлого 1.2 (4.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Улсын хэмжээнд архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг газруудын ажиллах цагийн хуваарийг багасгаж, амралтын газар, баар, бүжгийн клубийн үйл ажиллагааг зогсоосноор улсын төсөвт төвлөрөх онцгой албан татварын орлого буурахад нөлөөлсөн байна. Дотоодын архи, дарс, пивоны онцгой албан татвар энэ оны эхний хагас жилийн байдлаар 24.3 (22.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

ГАДААД ХУДАЛДАА

Манай улс 2020 оны эхний 8 сард нийт 139 улстай худалдаа хийсэн ч нийт бараа эргэлтийн 55.8 хувийг БНХАУ эзэлж байна. Нийт бараа эргэлт 7.9 тэрбум америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 1.5 (16.3%) тэрбум америк доллароор буурахад БНХАУ-тай хийсэн нийт экспорт 1.6 (33.7%) тэрбум америк доллароор, импорт 93.0 (6.9%) сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 8. Экспортын гол түнш улсууд, жил бүрийн эхний хагас жилд


Улс орон	2018 I-VIII		2019 I-VIII		2020* I-VIII	
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь
Дүн	4 671.2	100.0	5 387.1	100.0	4 478.9	100.0
БНХАУ	4 341.5	92.9	4 776.9	88.7	3 167.2	70.7
Швейцар	0.6	0.0	0.3	0.0	1 040.0	23.2
Сингапур	15.7	0.3	139.7	2.6	91.1	2.0
Их Британи	159.0	3.4	263.0	4.9	81.5	1.8
ОХУ	55.7	1.2	46.4	0.9	32.8	0.7
Бусад	98.8	2.1	160.8	3.0	66.3	1.5

БНХАУ-д хийсэн экспорт нь манай улсын нийт экспортын дүнгийн 70.7 хувийг бүрдүүлж байна.

БНХАУ-д гаргасан бараа бүтээгдэхүүний 35.1 хувийг чулуун нүүрс, 31.9 хувийг зэсийн баяжмал эзэлж байгаа бол Швейцар улсад экспортолсон барааны 99.8 хувийг, Сингапур улсад экспортолсон барааны 65.9 хувийг, Их Британи улсад экспортолсон барааны 59.2 хувийг алтны экспорт эзэлж байна.

Экспорт 2020 оны эхний 8 сард 4.5 тэрбум америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 908.2 (16.9%) сая америк доллароор буурсан байна. Харин 8 дугаар сард экспорт 690.2 сая америк доллар болж, өмнөх сараас 270.3 (28.1%) сая америк доллароор буурсан байна.

Зураг 8. Уул уурхайн гаралтай экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн, сая америк доллароор



Энэ оны эхний 8 сарын байдлаар экспортын 67.6 хувийг эрдэс бүтээгдэхүүний экспорт эзэлж байгаа ба нийт экспорт өмнөх оны мөн үеэс буурахад зэсийн баяжмалын экспорт 317.7 сая америк доллар, нүүрсний экспорт 967.7 сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Харин төв банк алт худалдан авах замаар нөөцөө нэмэх, экспортлогч компаниудтай хамтран ажиллах замаар валютын орох урсгалыг нэмэгдүүлэхээр ажиллаж байгаа нь алтны экспортыг өнгөрсөн оны мөн үеэс 3.3 дахин нэмэгдүүлж, 1.1 тэрбум америк долларт хүргэсэн байна.

Импорт 2020 оны эхний 8 сард 3.5 тэрбум америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 638.0 (15.6%) сая америк доллароор буурсан байна. Харин энэ оны 8 дугаар сард импорт 511.2 сая америк доллар болж, өмнөх сараас 29.3 (6.1%) сая америк доллароор өссөн байна.

Импорт өмнөх оны мөн үеэс буурахад автобензиний импорт 60.3 сая америк доллар, дизелийн түлшний импорт 186.3 сая америк доллар, суудлын автомашины импорт 124.9 сая америк доллар, ачааны автомашины импорт 65.2 сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний импортыг улсаар авч үзвэл 2020 оны эхний 8 сард өндөгний 99.3 хувийг ОХУ-аас, шувууны махны 81.7 хувийг БНХАУ-аас, цагаан будааны 44.7 хувийг БНХАУ-аас, 39.2 хувийг Вьетнам улсаас, элсэн чихрийн 46.2 хувийг Тайланд улсаас, 32.5 хувийг ОХУ-аас, маргаринь 88.6 хувийг ОХУ-аас тус тус импортолсон байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өндөг, шувууны мах, цагаан будаа, ургамлын тос, элсэн чихэр, гахайн мах, улаан буудайн импорт 9.6 хувиас 13.2 дахин өсөж, харин хуурай сүү төмсний импорт 27.5-97.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 9. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний импорт, мян.ам доллар

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2018 I-VIII		2019 I-VIII		2020* I-VIII		2020* I-VIII / 2019 I-VIII	
		Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ
Улаан буудай	мян.тонн	231.5	44 250.2	8.3	1 542.9	108.6	22 606.9	13.2 ¹	14.7 ¹
Гахайн мах	тонн	4 737.9	7 190.4	2 692.1	5 662.6	4 442.8	9 338.3	165.0	164.9
Шувууны мах	тонн	6 953.9	12 517.1	8 749.5	16 468.7	9 839.0	15 762.5	112.5	95.7
Өндөг	сая.шир	96.3	6 080.9	99.8	6 492.8	109.4	6 504.4	109.6	100.2
Төмс	тонн	2 876.4	562.7	374.3	75.0	8.9	2.0	2.4	2.7
Хуурай сүү	тонн	3 995.0	10 144.9	4 301.6	10 670.2	3 119.9	8 827.3	72.5	82.7
Цагаан будаа	мян.тонн	28.5	17 121.6	27.3	14 861.7	35.7	19 210.1	130.9	129.3
Ургамлын тос	тонн	9 406.0	9 088.7	8 355.0	7 459.7	10 999.7	10 009.6	131.7	134.2
Элсэн чихэр	мян.тонн	48.8	22 994.5	29.0	12 693.8	42.8	18 305.5	147.4	144.2

¹дахин их

АЧАА БОЛОН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Коронавируст халдвар (COVID-19) дэлхий дахинд гарсантай холбогдуулан Монгол Улсын хилийн боомтуудыг энэ оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс хааж, зорчигчдын орох, гарах урсгалыг хязгаарласан. Мөн халдварт өвчнөөс сэргийлж иргэд хот хооронд зорчихдоо өөрсдийн тээврийн хэрэгслээр явахыг илүүд үзэж байгаагаас бүх төрлийн тээврээр зорчигчдын тоо буурч байна.

Бүх төрлийн тээврээр 2020 оны эхний хагас жилд 61.8 сая хүн (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үеэс 29.3 (32.1%) сая хүнээр буурсан байна. Зорчигчдын тоо буурахад авто тээврээр зорчигчид 28.5 (32.0%) сая хүнээр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хэдийгээр хорио цээрийн дэглэмд буй ч ачаа тээвэрлэлт, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг бууруулахгүй байх нь эдийн засгийн эргэлтийг хэвийн байлгахад чухал үүрэгтэй учир хилийн боомтуудыг хэсэгчлэн нээж, үүний зэрэгцээ БНХАУ-ын эдийн засаг хүлээлтээс хурдан сайжирч байгаа учир уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт сэргэж байна.

Хүснэгт 10. Авто тээврийн үндсэн үзүүлэлт


Үзүүлэлт	2017 I-VI	2018 I-VI	2019 I-VI	2020* I-VI
Тээсэн ачаа, сая тонн	17.7	20.3	18.9	8.4
Уул уурхайн бүтээгдэхүүн	15.2	17.2	16.1	7.1
Зорчигчид, сая хүн	104.3	97.5	89.2	60.9
Нийслэлийн нийтийн тээвэр	96.6	90.4	81.4	55.2
Тээврийн орлого, тэрбум төгрөг	272.6	332.5	335.9	184.8

Авто тээврээр 2020 оны эхний хагас жилд 8.4 сая тонн ачаа тээвэрлэсний 84.5 хувь буюу 7.1 сая тонн ачаа нь уул уурхайн бүтээгдэхүүн байсан байна. Тээсэн ачаа өмнөх оны мөн үеэс 10.5 (55.5%) сая

тонноор буурсан бол өмнөх улирлаас 2.2 (69.4%) сая тонноор өссөн байна.

Авто тээврийн салбарын орлого энэ оны эхний хагас жилд 184.8 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 151.1 (45.0%) тэрбум төгрөгөөр буурсан бол өмнөх улирлаас 12.9 (15.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн орлого өссөн нь голлон нөлөөлсөн байна

Зураг 9. Төмөр замын тээврээр тээсэн ачаа, мянган тонн, сараар




Төмөр замын тээврээр 2020 оны эхний 8 сард 19.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.4 (7.6%) сая тонноор өсжээ.

Төмөр замын тээврээр тээсэн ачааны 83.2 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байна.

Төмөр замын тээврийн орлого 2020 оны эхний 8 сард 507.5 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 41.5 (8.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүн, тухайлбал төмрийн хүдэр, жонш мөн барилгын материалын тээвэрлэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 8. Агаарын тээврээр тээсэн ачаа, тонн, сараар



Агаарын тээврээр 2020 оны эхний 8 сард 1.8 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.9 (52.4%) мянган тонноор буурсан байна.

Харин зорчигчид 362.4 мянга (давхардсан тоогоор) болж, өмнөх оны мөн үеэс 739.8 (67.1%) мянган хүнээр буурсан байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2020 оны эхний 8 сард 110.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 251.6 (69.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

ДҮГНЭЛТ

COVID-19 цар тахлын дэгдэлт болон БНХАУ-ын эдийн засгийн удаашралын улмаас ашигт малтмалын түүхий эдийн эрэлт багассан нь Монгол Улсын нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, газрын тосны экспорт буурч, эдийн засаг агшихад хүргэсэн.

Инфляцын түвшин 2020 оны 8 дугаар сард 2.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 6.8 пунктээр буурсан байна. Инфляц төв банкны зорилтод түвшнээс (8%) буурч байгаа нь эдийн засгийн идэвх суларсныг илтгэж байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартой харьцах сарын дундаж ханш 2020 оны 8 дугаар сард өмнөх сараас 0.4 хувиар, юаньтай харьцах сарын дундаж ханш 1.7 хувиар суларч, рубльтэй харьцах сарын дундаж ханш өмнөх сараас 2.6 хувиар чангарсан байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.3 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.8 пунктээр, хугацаа хэтэрсэн зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.2 пунктээр тус тус өссөн байна.

Улсын төсөвт төвлөрч буй аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ-ын орлого энэ оны эхний 8 сард өмнөх оноос буурч байгаа нь дотоодын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд доголдол учирсныг харуулж байна.

2020 оны эхний хагас жилд үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн 76.4 мянга буюу 79.4 хувь нь худалдаа болон үйлчилгээний салбарынх байна. Худалдааны салбарын нийт борлуулалт 2020 оны эхний 7 сард өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар, зочид буудлын салбарын орлого 2020 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 39.2 хувиар, нийтийн хоолны салбарын орлого 5.3 хувиар тус тус буурсан байна.

Улсын хэмжээнд архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг газруудын ажиллах цагийн хуваарийг багасгаж, амралтын газар, баар, бүжгийн клубийн үйл ажиллагааг зогсоосноор улсын төсөвт төвлөрөх онцгой албан татварын орлого буурахад нөлөөлсөн байна. Дотоодын архи, дарс, пивоны онцгой албан татвар энэ оны эхний хагас жилийн байдлаар 24.3 (22.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Улсын төсвийн 2020 оны нийт алдагдлыг ДНБ-ий 5.1 хувьтай тэнцүү байхаар тооцоолсон бол энэ оны эхний хагас жилийн байдлаар нэгдсэн төсвийн нийт алдагдал 2.2 их наяд төгрөг болж, ДНБ-ий 13.1 хувьтай тэнцэж байна. Харин энэ оны эхний 8 сарын байдлаар төсвийн тэнцлийн алдагдал 2.6 их наяд төгрөгт хүрсэн байна. Үүнд БНХАУ-ын эдийн засгийн удаашралын улмаас уул уурхайн түүхий эдийн эрэлт багасч, төсвийн орлогын бүрдэл саарч, харин Ковид-19 цар тахлын дэгдэлтээс сэргийлэн авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй холбоотойгоор төсвийн зарлага өсөж байгаа нь нөлөөлж байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл энэ оны эхний 8 сард өмнөх оны мөн үеэс 18.4 хувиар буурахад уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 25.5 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Уул уурхайн салбарын бууралтад нүүрс олборлолт 57.8 хувиар буурсан нөлөөлсөн ба үүнийг дагаад нүүрсний экспорт эхний 8 сарын байдлаар 45.3 хувиар буураад байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын дийлэнх хувийг бүрдүүлдэг нүүрсний тээврийг автозамаар тээвэрлэдэг ба авто тээврээр 2020 оны эхний хагас жилд 8.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 55.5 хувиар буурсан байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ҮНДЭСНИЙ ТООЦОО, ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ГАЗРЫН
ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ТҮҮВРИЙН АЛБА